

Өвчтөнд зориулсан мэдээлэл: Уг бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө анхааралтай уншина уу

Tamarinlax гэдэс цэвэрлэх чанамал

Энэхүү эмэнд хамаарахгүй эмчилгээний бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө дараах мэдээллийг сайтар уншина уу. Учир нь танд чухал мэдээлэл агуулж байгаа болно! Энэхүү эмэнд хамаарахгүй эмчилгээний бүтээгдэхүүнийг та зааврийн дагуу болон эмчийн зөвлөсний дагуу хэрэглэнэ үү!

- Энэхүү зааврыг хадгалж авна уу, учир нь хожим хэрэгтэй байж магадгүй.
- Хэрэв танд ямар нэг гаж нөлөө илэрвэл эмчдээ эсвэл эмийн санчдаа мэдэгдээрэй. Энэ нь зааварт дурдагдаагүй бусад гаж нөлөө байж мэднэ.
- Хэрэв таны шинж тэмдгүүд сайжрахгүй эсвэл дордвол заавал эмчид хандаарай.

Шинж чанар үйлчлэл:

Tamarinlax туулгах чанамал нь эмэнд хамаарахгүй эмчилгээний бүтээгдэхүүн бөгөөд үйлчлэлийг нь шинжлэх ухааны судалгааны баримт нотолдог.

Бүтээгдэхүүний идэвхтэй бодис юу вэ?

1 кофены халбага (3,44 г) чанамалд агуулагдах: 0,86 г туулгах ханд (гашуун гоньд, хар бөөрөлзгөнө цэцэг, кориандрын үр, амтат үндэс), 1,38 г тамаринд модны боловсорсон жимсний усан ханд.

Бүтээгдэхүүнд өөр юу агуулагддаг вэ?

Метил-парагидроксibenзоат, этанол (96% V/V), гидроксипропилцеллюлоз, сахароз ($\sim$ 1 г / кофены халбага).

Бүтээгдэхүүнийг хэрэглэхэд хэзээ тохиромжтой вэ?

- Цочмог болон архаг өтгөн хаталт,
- Хүнд, өвдөлттэй, тогмол бус өтгөн гадагшлалт (шамбарам, мэс заслын дараах байдал),
- Насжилттай холбоотой гэдэсний сулрал.

Бүтээгдэхүүнийг хүүхдүүд хэрэглэж болох уу?

Бага насны хүүхдүүдэд энэхүү чанамалыг хэрэглэхийг аюулгүй байдлын мэдээлэл дутмаг тул зөвлөдөггүй. Хүүхдүүд 5 наснаас дээш насанд хэрэглэх боломжтой.

Чанамалыг эмүүдтэй зэрэг хэрэглэх боломжтой юу?

Шээс хөөдөг эм, зүрхний гликозид, кортикостероид, бусад туулгах эм болон электролитийн тэнцвэрийг алдагдуулах эмүүдтэй зэрэг хэрэглэхийг зөвлөдөггүй. Хэрэв та эдгээр төрлийн эмийг хэрэглэдэг бол чанамалыг хэрэглэхийн өмнө эмчлэгч эмчтэйгээ

зөвлөлдөөрэй Чанамал болон бусад бүтээгдэхүүнийг хэрэглэх хооронд хамгийн багадаа 1–2 цагийн зайтай байх хэрэгтэй.

Хэрэв та хөхүүл, жирэмсэн эсвэл хүүхэдтэй болохыг хүсэж байгаа бол яах вэ?

Эдгээр амьдралын нөхцөлд та туулгах эм хэрэглэх шаардлагатай бол уг бүтээгдэхүүнийг хэрэглэх боломжтой, учир нь хүчтэй үйлчлэлтэй антракинонууд агуулаагүй. Чанамалын идэвхтэй бодисууд урагт дамжих эсвэл хөхний сүүгээр дамжин нярайд хүрэх боломжтой тул ийм тохиолдолд удаан хугацаагаар хэрэглэх тухай эмчлэгч эмчтэйгээ зөвлөлдөөрэй.

Чанамал хэрэглэх нь тээврийн хэрэгсэл жолоодох болон машин тоног төхөөрөмж ажиллуулах чадварт нөлөөлөх үү?

Чанамал хэрэглэх нь дээрх үйл ажиллагаанд нөлөөлөхгүй.

Зөвлөмж болгох тун юу вэ?

- Насанд хүрэгчдэд 1-2 кофены халбага
- Өсвөр насныханд (12 наснаас дээш): 1 кофены халбага
- Хүүхдүүдэд (5-12 нас) ½ кофены халбага хэрэглэхийг зөвлөнө

Бүтээгдэхүүнийг хэрхэн хэзээ хэрэглэх вэ?

Оройн хоолны дараа хэрэглэхийг зөвлөдөг

Бүтээгдэхүүний гаж нөлөө юу вэ?

Хувийн хэт мэдрэг байдал (арьсны болон амьсгалын замын харшлын урвал), мөн хэвлийн доод хэсгийн өвдөлт, гэдэсний өвчин зэрэг байж болно. Хэт их хэрэглэвэл электролитийн алдагдал (ялангуяа кали алдагдсанаар зүрхний үйл) ажиллагаа алдагдах, булчингийн сулрал үүсэх) үүсэж болно. Хэрэв танд ямар нэгэн гаж нөлөө илэрвэл эмчлэгч эмч эсвэл эм зүйчид хандана уу. Энэ нь бүтээгдэхүүний зааварт дурдагдаагүй боломжит бусад гаж нөлөөнд ч хамаарна.

Бүтээгдэхүүнийг хэрэглэх үед юуг анхаарах вэ?

Зүрхний өвчтэй хүмүүс, ялангуяа зүрхний гликозид болон эсвэл шээс хөөдөг эм хэрэглэдэг бол бүтээгдэхүүнийг болгоомжтой хэрэглээрэй! Хүүхдээс хол байлга.

Бүтээгдэхүүнийг хэр удаан хэрэглэж болох вэ?

Чанамалыг гомдол арилтал хэрэглэнэ. Хэрэв 5-7 хоногийн хэрэглээний дараа гомдол хэвээр байвал эсвэл дордвол чанамал хэрэглэхээ зогсоож эмчтэйгээ зөвлөлдөөрэй.

Бүтээгдэхүүнийг хэрхэн хадгалах вэ?

25°C-аас ихгүй температурт хадгална.

Чанамалын өнгө болон савалгаа ямар вэ?

Тайлбар: Хар хүрэн өнгөтэй, өтгөн, онцлог үнэртэй, исгэлэн амттай чанамал. Савалгаа: 150 мл-ийн бор шилэн сав, цагаан эргэлтгүй тагтай, шилэн таглаатай, хайрцагтай.

Савлагааны хэмжээ: 150 г/шил/хайрцаг

Бүртгэлийн дугаар: OGYI-582/1996

Зах зээлд нэвтрүүлэх зөвшөөрөл эзэмшигч: Herbária Zrt.

1135 Будапешт, Csata гудамж 27.

Дистрибьютер: Монгол улс, Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг 1-р хороо 36- байр
“Камеллиа пинк” ХХК

Утас: 90006233

WW34+PWW, SBD - 1 khoroo, Ulaanbaatar 17031